



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/127

Сүхбаатар сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих" журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг досрх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Аймгийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Татварын хэлтсийн Татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Цагдаагийн газрын Нийгмийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандарт хяналтын улсын байцаагч

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Баталгаажуулалтын ахлах шинжээч

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, нийтийн хоол, худалдаа хариуцсан мэргэжилтэн

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагааг сайтар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/74 тоот захирамжийг хүчингүйд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ